

## ЭРДЭНЭ РЕСУРС 2021 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ  
Нова Скошиа муж, Халифакс хот  
2021.11.10

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани")** нь 2021 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төсөл ("Баян Хөндий" эсвэл "БХ")-ийн хөгжүүлэлтийн мэдээлэл хүргэж байна. 2021 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан ("MD&A" буюу "Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээ") нь энэхүү хэвлэлийн мэдээний салшгүй нэг хэсэг болно.

### Онцлох мэдээлэл:

- Хайгуулын судалгаагаар Баян Хөндий, Улаан болон Хар Морийн Дэл бүс нь нэгдсэн томоохон алтны эрдэсжсэн системийн хэсгүүд гэдгийг тодорхойллоо:
  - Улаан талбайн өмнөд бүсэд хийсэн нээлтээр Хөндий алтны дүүрэгт илрүүлсэн хамгийн өргөн интервал бүхий алтны эрдэсжилтийг огтолсон.
  - Хар Морийн Дэл талбайн нарийвчилсан хайгуулын өрөмдлөгийн үр дүнгүүдийг 11 сарын дундуур танилцуулна.
- Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлт
  - 10 сарын 5-нд Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны Мэргэжлийн Зөвлөл нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-г батлах шийдвэр гаргасан.
  - Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газартай Хамтын ажиллагааны гэрээг байгуулан, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн.
  - Нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажлууд 90% гүйцэтгэлтэй байгаа нь ирэх саруудад бэлтгэл ажлуудыг эхлүүлэх боломжийг бүрдүүлэв.
- 10 сарын 8-нд Монголын Хөрөнгийн Бирж дээр 5 сая ам.долларын санхүүжилт татан төвлөрүүлсэн.

### Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Бид гуравдугаар улиралд Баян Хөндий алтны төслийг хөгжүүлэх, мөн Хөндий Алтны Дүүргийг тэлэх хоёр стратегийн зорилтын дагуу амжилттай ажилласан. Улаан

талбайн өмнөд бүсийг тэлсэн нь Хөндий Алтны Дүүрэг дэх Хөндий-Улаан системийн хэтийн төлөвийг харуулж байна. Эрдэнэ Ресурс нь 2022 онд нөөцийн хэмжээг 2 сая унц алтад хүргэх зорилгын хүрээнд 2021 оны эцэст 3,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.”

“Бид Ковид-19 цар тахлаас үүссэн тодорхойгүй байдлуудыг үл харгалзан Баян Хөндийн бүтээн байгуулалтын шийдвэрийг гаргахад зориулж бэлтгэл ажлуудыг тууштай ахиулж байна. Компани нь 2021 оны 4-р улиралд бэлтгэл ажлуудыг гүйцэтгэн, 2022 оны эхнээс бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. Түүнээс гадна Компани нь Ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн гол тоног төхөөрөмжүүдийн зардал, нийлүүлэлтэд үүсэж болзошгүй эрсдэлийг хянан, ирэх саруудад төсөл хөгжүүлэлтийн төлөвлөгөө болон төсвийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхөөр төлөвлөж байна.”

### 2021 оны гуравдугаар улирлын онцлох үйл явдлууд:

#### Баян Хөндий Алтны Төсөл – 100% Эрдэнэ Ресурсийн эзэмшил

- Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлууд эхэлсэн
  - Боловсруулах үйлдвэр ба уурхайн бусад дэд бүтцийн нарийвчилсан зураг төсөл, инженерчлэлийн ажлууд 90% гүйцэтгэлтэй байна.
  - Нарийвчилсан загварчлалыг захиргааны байгууллагууд хянаж буй бөгөөд 8 байгууламжийн барилгын зөвшөөрлийг авсан.
  - 2021 оны 4-р улиралд бэлтгэл ажлын хүрээнд үндсэн хуваарь, худалдан авалтын ажлуудыг эрчимжүүлсэн.
- Уурхайн хөгжүүлэлтийг эхлүүлэхэд шаардлагатай захиргааны байгууллагуудын зөвшөөрлүүдийг авч байна
  - 2021 оны 10 сарын 5-нд Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны Мэргэжлийн Зөвлөл төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ)-г хүлээн авсан.
- Орон нутгийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна
  - Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээнд чиглэсэн орон нутгийн санаачлагуудыг хэрэгжүүлсэн.
  - Орон нутгийн иргэдийг хүнд даацын машин механизмын ашиглалт, уурхайн бүтээн байгуулалтын сургалтад хамруулсан.

#### Хайгуулын хөтөлбөр

- Баян Хөндий алтны ордоос баруун зүгт 300 метрт Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн алтны шинэ нээлтийг тэлэв
  - Хөндий Алтны Дүүрэг дэх хамгийн зузаан алтны интервалыг огтолсон
    - UDH-10 цооногийн 92 метрт 0.98 г/т алтны агуулга бүхий 258 метр интервал огтолсон нь 3.77 г/т алтны агуулга бүхий 40 метрийн интервал агуулж байна.

- UDH-14 цооногийн 188 метрээс эхлэн 1.07 г/т алтны агуулга бүхий 216.6 метр интервал огтолсон нь 3.55 г/т алтны агуулга бүхий 53 метрийн интервал агуулсан.
  - UDH-15 цооногийн 97 метрээс эхлэн 0.79 г/т алтны агуулга бүхий 364 метр интервал огтолсон нь 1.98 г/т алтны агуулга бүхий 91 метр агуулж байна.
  - UDH-19 цооногийн 82 метрээс эхлэн 0.7 г/т алтны агуулга бүхий 190 метр огтолсон нь 12.52 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал агуулж байна.
  - UDH-21 цооногийн 115 метрээс эхлэн 3.19 г/т алтны агуулга бүхий 77 метр огтолсон нь 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метрийн интервал агуулж байна.
  - UDH-22 цооногийн 85 метрээс эхлэн 3.11 г/т алтны агуулга бүхий 65 метрийн интервал агуулсан 1.71 г/т алтны агуулга бүхий 152 метр огтолсон.
- 2021 оны 4-р улиралд 3,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэхээр төлөвлөсөн.
- Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км зайд, Хар Морь талбайд хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн.
    - 3-р улиралд Компани нь 2,286 тууш метрийн 34 цооног болон 2 цооногийн өргөтгөл өрөмдсөн – дээжүүдийг Улаанбаатар хот дахь SGS лабораторид хүргүүлсэн бөгөөд үр дүнгүүдийг 11-р сарын дундуур танилцуулна.
    - Геофизик, шавар эрдсийн шинжилгээ, петрограф, эрдэсжилт, хий, шингэний ормын мөрийн судалгаа болон 3D загварчлалын үнэлгээ, тайллын хөтөлбөр үргэлжлэн хийгдэж байна.

### Компанийн тухай

- 2021 оны 10-р сарын 8-нд Монголын Хөрөнгийн Бирж дээр 5 сая ам.долларын санхүүжилтийг татан төвлөрүүлсэн
  - Монголын стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтээс 1,867 захиалга хүлээн авсан
  - Хувьцааны захиалга 46%-иар давж биелсэн бөгөөд Монгол Улсын хууль, журмын дагуу хувь тэнцүүлэн биелүүлсэн
- Канадын Экспорт Хөгжлийн Агентлаг (EDC) болон Монголын санхүүгийн байгууллагуудтай Баян Хөндий Алтны Төслийн санхүүжилттэй холбоотой нарийвчилсан судалгааг гүйцэтгэж байна.
  - \$55 сая ам.доллар хүртэл зээлийн санхүүжилтийг төвлөрүүлэх зорилт бүхий баримт бичигт гарын үсэг зурсан нь нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэсэнээр эцэслэх нөхцөлтэй.
  - 2021 оны 1-р улиралд төслийн талбайд судалгаа хийсэн бөгөөд техник, байгаль орчин болон нийгмийн тайлангийн төслийг хүлээж авсан.
  - Канадын Экспорт Хөгжлийн Агентлагийн зээлийн баримт бичгийн үндэс болох Ерөнхий Нөхцөлүүдийн төслийг боловсруулсан.
  - Дээрх үйл ажиллагаатай зэрэгцэн нэмэлт зээлийн судалгааг Монгол Улсын санхүүгийн байгууллагууд гүйцэтгэж байна.

- Зуун Мод / Хөвийн Хар молибден-зэсийн төслийн стратеги, техникийн үнэлгээг эхлүүлсэн.
  - RPMGlobal нь шинэчилсэн техникийн судалгаа, эдийн засгийн тооцооллыг 11-р сарын дундуур хүлээлгэн өгнө.
  - Энэхүү үнэлгээ нь борлуулалт, түншлэл, хуваах зэрэг хэд хэдэн арга замыг тодорхойлж, төслийн үнэ цэнийг оновчлох зорилготой.
- 2021 оны 9 сарын 30-ны өдөр дуусгавар болсон 3 сарын хугацаанд Компанийн нийт алдагдал \$1,935,798 байсан ба 2020 оны 9 сарын 30-нд \$3,871,340 байв
  - Капиталжуулсан зардлыг оролцуулсан хайгуул болон үнэлгээний өртөг нь 2021 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд \$3,501,181 байсан нь 2020 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын \$3,547,222-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь 2021 оны 7-р сард хэрэгжүүлсэн Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээтэй холбоотой оролцогч талуудтай харилцах зардал өссөн, Баян Хөндий төслийн инженерчлэлтэй холбоотой уурхайн судалгааны зардал өссөн боловч гүйцэтгэлтэй холбогдсон мөнгөн бус хувьцаанд суурилсан нөхөн олговрын зардлыг хэсэгчлэн олгосонтой холбоотой зардал болон хайгуулын хөтөлбөрийн зардал харьцангуй буурсантай холбоотой.
  - Компанийн захиргаа, удирдлагын зардал нь 2021 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд \$565,092 байсан нь 2020 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын \$869,876-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь гүйцэтгэлтэй холбогдсон мөнгөн бус хувьцаанд суурилсан нөхөн олговрын зардал буурсантай холбоотой.

### Ковид-19 нөхцөл байдал

2020 оны нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын Засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөн, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ цар тахлаас хамгаалах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлсэн. 2020 оны 3-р сараас эхлэн Канад ба бусад улсуудын засгийн газрууд дээрхтэй ижил хязгаарлалтуудыг хэрэгжүүлж эхэлсэн. 2020 оны 11 сард Монгол Улсад цар тахал голомтлон тархсанаас үүдэн Монгол Улсын Засгийн газар дотоодын хөл хөдөлгөөн болон бараа материалын тээвэрлэлтэд хязгаарлалт хийсэн. 2021 оны эхэнд хязгаарлалтыг сулруулсан боловч бүртгэгдсэн тохиолдлуудын тоо нэмэгдсэний улмаас 2021 оны нэгдүгээр улирлын эхэн үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн.

2021 оны 3-р сарын эцэст Эрдэнэ Ресурсийн үйл ажиллагаа эрхэлдэг Баянхонгор аймагт Ковид-19-ийн халдварын эхний тархалт бүртгэгдсэнээр аймаг руу нэвтрэх болон гарах хязгаарлалт тогтоосон. Түүнээс гадна 2021 оны 6-р сарын эцэст Компанийн төсөл байрладаг Шинэжинст суманд Ковид-19-ийн халдварын тоо нэмэгдсэнээр хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон. Компани нь энэхүү хязгаарлалтын дэглэмийн хүрээнд 6 сарын сүүлээр хайгуулын ажлаа түр хугацаанд зогсоосон боловч 8-р сард хайгуулын ажлуудыг үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой

болсон. Мөн, Канадын болон олон улсын ажилтнууд, зөвлөхүүд нь 2021 оны 3-р улирлаас эхлэн Монгол Улсад томилолтоор ажиллах боломжтой болсон.

Монгол Улсад бүртгэгдэж буй Ковид-19-ийн хэмжээ буурахгүй байгаа нь БНХАУ-тай хил дээр бараа материалын гацалт үүсэхэд нөлөөлсөн. Энэхүү хил дээрх тодорхойгүй байдал нь Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтад шаардах үйлдвэрийн болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хүртээмж, үнэд нөлөөлж байна. Хэдийгээр өнөөг хүртэл Ковид-19 цар тахлын Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөлөл харьцангуй бага байсан боловч Баян Хөндий төслийн хөгжүүлэлтийн зардлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг удаашруулах магадлалтай. Компани нь Баян Хөндий Алтны Төслийн бүтээн байгуулалтын төлөвлөгөө, төсөвт үзүүлэх нөлөөллийг хянан, судалж байна. Иргэдийн зорчих хөдөлгөөн, бараа бүтээгдэхүүн Монгол Улс руу чөлөөтэй нэвтрүүлэх хүртэл бүтээн байгуулалтыг бүтэн хүчин чадлаар гүйцэтгэхэд бэрхшээлтэй. Компанийн үйл ажиллагаа, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтэд Ковид-19-ийн үзүүлэх нөлөөллийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг үргэлжлүүлэн хүргэнэ.

Эрдэнэ Ресурсийн бүх ажилтнууд нь Ковид-ийн эсрэг дархлаажуулалтын бүрэн тунд, олон ажилтнууд нэмэлт 3-р тунд хамрагдсан. Эрдэнэ Ресурс нь Монгол болон Канад Улсын эрх баригчидтай хамтран ажилтнуудын болон Компанийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалахын тулд хяналтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### Мэргэшсэн этгээд (геологич)

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geol., Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба хэвлэлийн мэдээг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно.

### Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com) -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

### Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө,

стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>